



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/39

Бор-Өндөр сум

**Сумын "Алдарт уяач" цол олгох
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний Их Баяр Наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сэцэн хааны хүлэг" морин спорт уяачдын холбооны 2022 оны 6/15 тоот албан бичгээр сум, тосгоны салбар холбоодын тэргүүн, нарийн бичгийн дарга нарт хүргүүлсэн чиглэлийн дагуу аймаг болон аймгийн бүсийн наадмын айраг, түрүүг дүйцүүлэн Бор-Өндөр сумын "Бор-Өндөрийн хурд" морин спорт уяачдын холбооноос 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн, Сумын баяр наадам, хурдан морьдын бүсийн уралдаанд түрүүлж, айрагдсан амжилтаараа "Үндэсний их баяр наадмын тухай хууль"-д заасан болзол хангасан уяач Найдансүрэнгийн Энхбатад "СУМЫН АЛДАРТ УЯАЧ" цол олгосугай.

2. Цол хүртээх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллахыг "Бор-Өндөрийн хурд" морин спорт уяачдын холбооны тэргүүн (С.Ганхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ